

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2011 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2011.9.01

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

Эхний хагас жилд нийт 18 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 10 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 190 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан бөгөөд 2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	139
2	2007 он	10	12	137
3	2008 он	10	15	132
4	2009 он	56	11	177
5	2010 он	20	15	182
6	2011 оны II улирал	18	10	190

2011 оны эхний хагас жилд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан ББСБ-уудыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

№	ББСБ-ын нэр	Эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Ашидтүвшин инвест	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
2	Монгорү матрикс гинго	Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх ба 100 хувийн Японы хөрөнгө оруулалттай
3	Даймонд файнанс	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
4	Си жи эм	Зээл, факторинг, төлбөрийн баталгаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
5	Эко капитал	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
6	ТДБ секьюритис	Зээл, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
7	Девелопинг энтерпренюриал монголиа	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
8	Төгөл инвест	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
9	Улаанбаатар капитал	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх итгэлцлийн үйлчилгээ, факторингийн үйлчилгээ	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх

10	Ард капитал	Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
11	ОСАБ	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
12	БСБ финанс	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
13	Их мөнгөн завьяа	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
14	Берилл финанс	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
15	Бүрэн инвест	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
16	Тэнгэр зууч	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
17	Буман дусал	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
18	Юу би кредит	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх

2011 оны 2 дугаар улиралд 10 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Үүнд


/Хүснэгт 3/

№	ББСБ-ын нэр	Эрхлэж байсан үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Сити хөгжил	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж, Төв аймгийн сумдын иргэдэд зээлийн үйлчилгээ хүргэж байсан
2	Арвижих хангай	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
3	Өнө ингүүмэл	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
4	Гэрэл инвест	Зээл	Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан
5	Обил	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
6	Шанх уул	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
7	Хөгжил эх	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
8	Актив инвест	Зээл, факторингийн үйлчилгээ	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
9	Элбэг зоос	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
10	Цэцэрлэг Ар	Зээл	Архангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан

Хорооны хуралдааны шийдвэрээр 2011 эхний хагас жилд 14 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 4 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



2011 оны 2 дугаар улирлын тайлант хугацааны ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 4/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны II улирал	2011 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
А. ББСБ-УУДЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ				
1	ББСБ-ын тоо	188	190	2
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	590	600	10
3	Ажиллагсадын тоо	870	982	112
4	Салбар нэгжийн тоо	60	67	7
5	Харилцагчдын тоо	76,280.0	97,033.0	20,753.0
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	115,539,684.7	167,715,818.2	52,176,133.5
Банкны салбарт эзлэх хувь		2.18%	2.34%	-0.2%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	67,754,807.0	100,926,240.9	33,171,433.9
Банкны салбарт эзлэх хувь		2.23%	2.38%	-0.1%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	85,749,294.0	119,933,011.0	34,183,717.0
Банкны салбарт эзлэх хувь		23.72%	30.16%	-6.4%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	77,179,517.4	105,336,294.0	28,156,776.6
Банкны салбарт эзлэх хувь		42.23%	28.17%	14.06%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	8,290,125.9	8,726,211.6	436,085.7
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	13,516,457.4	19,347,435.0	5,830,977.6
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	10,454,217.3	14,969,130.8	4,514,913.5
13	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	3,062,240.2	4,378,304.2	1,316,064.0
Б. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ББСБ-УУДЫН ҮЗҮҮЛЭЛТ				
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	11	15	4
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		7.89%	5.85%	2.0%
2	Нийт актив /мянган төгрөгөөр/	18,125,991.5	23,591,264.9	5,465,273.4
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		14.07%	15.69%	-1.6%
3	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	13,542,246.4	18,525,910.3	4,983,663.9
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		18.36%	19.99%	-1.6%
4	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,633,018.4	12,354,233.6	4,721,215
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		10.30%	8.90%	1.4%

5	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8,267,792.5	10,023,749.0	1,755,956.5
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		9.52%	10.71%	-1.2%
В. ОРОН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ББСБ-УУДЫН ҮЗҮҮЛЭЛТ				
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	27	24	-3
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		12.63%	14.36%	-1.7%
2	Нийт актив /мянган төгрөгөөр/	3,559,106.9	4,461,575.0	902,468
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		2.66%	3.08%	-0.4%
3	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,440,612.0	5,466,892.0	1,026,280.0
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		5.42%	6.55%	-1.1%
4	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	3,381,867.1	4,227,494.0	845,626.9
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		3.52%	3.94%	-0.4%
5	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,301,937.59	3,858,621.7	556,684.1
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		3.66%	4.28%	-0.6%
Г. ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ББСБ-УУДЫН ҮЗҮҮЛЭЛТ				
1	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	49	47	-2
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		24.74%	26.06%	-1.3%
2	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,766,366.51	7,445,362.71	1,678,996.2
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		4.44%	4.99%	-0.6%
3	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,747,582.62	7,335,563.49	1,587,980.9
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		6.12%	6.70%	-0.6%
4	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,029,422.43	6,604,692.37	1,575,269.9
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		6.27%	6.52%	-0.2%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

Гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 15 ББСБ-ыг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 8, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, ОХУ болон Итали улсын хөрөнгө оруулалттай тус бүр 1 байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	ББСБ-ын нэр	Гадаадын хөрөнгө оруулагчийн харьяалал	Гадаадын хөрөнгө оруулалтын хувь
1	Сар шинэ интернэшнл	Япон	46.3
2	Марико	Япон	87.5
3	Вишн фаунд	Зөн сан Монгол	100.0
4	Мөнгөнбүрэн	БНСУ	29.0
5	Футур эволюшн	Итали	100.0
6	Цагаан ажнай	Япон	100.0
7	Жи Си Ай Пи	Япон	51.0
8	Монгол факторинг	ОХУ	47.5
9	Жэй эй эс эм	Япон	100.0

10	Фүжи холдинг	Япон	66.7
11	Их түншлэл	БНСУ	70.0
12	Жэй си финанс	Япон	100.0
13	Чингис хаан холдинг	БНСУ	58.6
14	Монгол пасифик	БНСУ	100.0
15	Монгору матрикс гинго	Япон	100.0

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2011 оны 2 дугаар улирлын байдлаар орон нутагт төвтэй 24 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 12.6 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 2.6 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 5.4 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.5 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.6 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/График 2/



Валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

Валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 45 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 2 ББСБ буюу нийт 47 ББСБ валютын арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 24.7 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 4.4 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 6.1 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 6.3 хувийг тус тус эзэлж байна.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант улиралд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ХӨРӨНГӨ	2010.06.30		2011.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	110,793,997.5	95.9	161,487,262.7	96.3	50,693,265.2	45.8
1	Мөнгөн хөрөнгө	35,949,875.9	31.1	49,039,660.2	29.2	13,089,784.3	36.4
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,925,390.2	1.7	1,867,552.4	1.1	-57,837.8	-3.0
3	Нийт зээл	67,754,807.0	58.6	100,926,240.9	60.2	33,171,433.9	49.0
	(Зээлийн эрсдэлийн сан)	3,855,103.4	3.3	3,519,123.9	2.1	-335,979.5	-8.7

4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,383,549.5	1.2	2,303,831.4	1.4	920,281.9	66.5
	(Санхүүгийн түрээсийн эрсдэлийн сан)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Нийт факторингийн тооцооны авлага	134,469.9	0.1	1,929,780.0	1.2	1,795,310.1	1335.1
	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	350.0	0.0	0.0	0.0	-350.0	-100.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	463,570.5	0.4	555,721.7	0.3	92,151.2	19.9
7	Бусад хөрөнгө	7,037,438.0	6.1	8,383,600.0	5.0	1,346,162.0	19.1
Б	Эргэлтийн бус хөрөнгө	4,745,687.1	4.1	6,228,555.5	3.7	1,482,868.4	31.2
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,745,687.1	4.1	6,228,555.5	3.7	1,482,868.4	31.2
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,218,002.0	5.4	8,071,094.7	4.8	1,853,092.6	29.8
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,472,314.9	1.3	1,842,539.2	1.1	370,224.3	25.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		115,539,684.7	100.0	167,715,818.2	100.0	52,176,133.6	45.2

ББСБ-ын 2011 оны 2 дугаар улирлын нийт актив өмнөх оны мөн үеэс 45.2 хувиар өсөхөд хуримтлагдсан ашиг, нийт өр төлбөр, дүрмийн сангийн /хувьцаат капитал/ өсөлтүүд гол нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт активын 60.2 хувийг зээл, 29.2 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж байгаа нь нийт активын 89.4 хувь болж байна.

Нийт активын 56.4 хувийг нэр бүхий 20 ББСБ бүрдүүлж байна.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 7/

№	Ангилал	2010.06.30		2011.06.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.тог/	Хувь	Дүн /мян.тог/	Хувь	Дүн /мян.тог/	Хувь
1	Хэвийн	59,799,535.1	88.3%	93,759,363.0	92.9%	33,959,827.9	56.8%
2	Хугацаа хэтэрсэн	2,866,070.1	4.2%	2,219,675.9	2.2%	-646,394.2	-22.6%
3	Чанаргүй зээл. Үүнээс	5,089,201.8	7.5%	4,947,202.0	4.9%	-141,999.8	-2.8%
	Хэвийн бус	875,564.5	1.3%	1,169,335.9	1.2%	293,771.3	33.6%
	Эргэлзээтэй	1,495,575.2	2.2%	1,320,573.2	1.3%	-175,002.0	-11.7%
	Муу	2,718,062.1	4.0%	2,457,293.0	2.4%	-260,769.1	-9.6%
	(Зээлийн эрсдэлийн сан)	3,855,103.4	5.7%	3,519,123.9	3.5%	-335,979.5	-8.7%
	Нийт зээл	67,754,807.0	100.0%	100,926,240.9	100.0%	33,171,433.9	49.0%

ББСБ-ын 2011 оны 2 дугаар улиралын зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 49.0 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 56.8 хувиар өссөн бол, чанаргүй зээл 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй нийт 190 ББСБ-аас 75,8 хувь буюу 144 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж дээд хүү 3.7 хувь, зээлийн дундаж доод хүү 2.0 хувь байна.

ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2011 оны 2 дугаар улирлын тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.06.30		2011.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	25,458,260.2	22.0%	41,904,564.6	25.0%	16,446,304.3	64.6%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,406,108.2	4.7%	8,726,211.6	5.2%	3,320,103.4	61.4%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	15,431,118.6	13.4%	25,567,969.9	15.2%	10,136,851.3	65.7%
3	Бусад эх үүсвэр	599,714.5	0.5%	2,179,671.8	1.3%	1,579,957.3	263.5%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	1,059.3	0.0%	0.0	0.0%	-1,059.3	-100.0%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	591,299.2	0.5%	1,998,514.4	1.2%	1,407,215.2	238.0%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,656.6	0.0%	26,231.5	0.0%	22,574.9	0.0%
	Факторингийн үйлчилгээний өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0%	154,925.9	0.1%	151,226.5	4087.9%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	296,000.0	0.3%	400,000.0	0.2%	104,000.0	35.1%
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,725,319.0	3.2%	5,030,711.3	3.0%	1,305,392.3	35.0%
	Бусад өр төлбөр	4,332,130.5	3.7%	5,878,242.7	3.5%	1,546,112.2	35.7%
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	685,000.3	0.6%	2,052,224.0	1.2%	1,367,223.7	199.6%
7	Бусад пассив	3,647,130.2	3.2%	3,826,018.7	2.3%	178,888.5	4.9%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	Нийт өр төлбөр	29,790,390.7	25.8%	47,782,807.2	28.5%	17,992,416.6	60.4%
Б	Эзэмшигчдийн өмч	85,749,294.0	74.2%	119,933,011.0	71.5%	34,183,717.0	39.9%
9	Хувьцаат капитал	77,179,517.4	66.8%	105,336,294.0	62.8%	28,156,776.6	36.5%
10	Бусад өмч	600,414.6	0.5%	2,401,847.8	1.4%	1,801,433.2	300.0%
11	Сангууд	1,136,670.8	1.0%	1,140,548.0	0.7%	3,877.2	0.3%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	5,954,328.8	5.2%	8,391,022.1	5.0%	2,436,693.3	40.9%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	878,362.5	0.8%	2,663,299.1	1.6%	1,784,936.6	203.2%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	115,539,684.7	100.0	167,715,818.2	100.0	52,176,133.6	45.2%

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 64.6 хувиар, эзэмшигчдийн өмч 39.9 хувиар өссөн ба 2010 оны 2 дугаар улиралд нийт эх үүсвэрийн 25.8 хувийг нийт өр төлбөр, 74.2 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2011 оны 2 дугаар улирлын байдлаар нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр 28.5 хувь, эзэмшигчийн өмч 71.5 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөн түүнчлэн ББСБ-уудын дүрмийн сан болон хуримтлагдсан ашиг өссөн байна.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрэлт нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсөж байна.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Өөрийн хөрөнгийн өсөлтөд Хорооны 2008 “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн санг нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэсэн.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2011 оны 2 дугаар улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30		2011.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	6,855,222.8	51.2	13,182,842.2	68.1	6,327,619.5	92.3
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	6,569,576.2	49.1	12,434,023.2	64.3	5,864,447.0	89.3
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	210,605.2	1.6	272,702.8	1.4	62,097.6	29.5
	Үнэт цаасны хүүгийн орлого	2,070.9	0.0	0.0	0.0	-2,070.9	-100
	Бусад хүүгийн орлого	72,970.4	0.5	476,116.2	2.5	403,145.8	552.5
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	6,292,710.5	47.0	5,701,177.8	29.5	-591,532.7	-9.4
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	224,292.8	1.7	455,858.6	2.4	231,565.8	103.2
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	7,740.2	0.1	7,556.4	0.0	-183.8	-2.4
	НИЙТ ОРЛОГО	13,379,966.3	100.0	19,347,435.0	100.0	5,967,468.8	44.6

2011 оны 2 дугаар улирлын орлого өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлт зэрэг нь үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж улмаар үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлогын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна.

Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар буурсан байх ба тайлант хугацааны нийт орлогын 68.1 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 92.3 хувиар өссөн/, 29.5 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 9.4 хувиар буурсан/ эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 10/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30		2011.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	830,510.4	7.6	2,205,500.8	14.7	1,374,990.4	165.6
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	8,301,072.2	76.3	11,017,466.7	73.6	2,716,394.4	32.7
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,302,073.0	12.0	941,431.5	6.3	-360,641.5	-27.7
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	119,617.4	1.1	223,654.7	1.5	104,037.3	87.0

5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	6,586.1	0.1	7,209.1	0.0	623.1	9.5
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	319,696.3	2.9	573,867.9	3.8	254,171.6	79.5
	НИЙТ ЗАРДАЛ	10,879,555.5	100.0	14,969,130.8	100.0	4,089,575.3	37.6

2011 оны 2 дугаар улирлын нийт зардал өмнөх оны мөн үеэс 37.6 хувиар өссөнөөс хүүгийн зардал 165.6 хувиар, хүүгийн бус зардал 32.7 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 87.0 хувиар, орлогын татварын зардал 79.5 хувиар тус тус өсч, болзошгүй эрсдэлийн зардал 27.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-ын 2011 оны 2 дугаар улирлын нийт орлого өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар, нийт зардал 37.6 хувиар тус тус өссөн байна.

2011 оны 2 дугаар улиралд нийт 4,378,304.2 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 75.1 хувийн өсөлттэй байна.

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30	2011.06.30	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	13,516,457.40	19,347,435.0	5,967,468.8
2	НИЙТ ЗАРДАЛ	10,454,217.30	14,969,130.8	4,089,575.3
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	3,062,240.1	4,378,304.2	1,877,893.5

Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлтөөс гадна тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн байна.

Тайлант улиралд 161 ББСБ буюу нийт ББСБ-ын 84.7 хувь нь ямар нэг хэмжээгээр ашигтай ажилласан ба тэдгээрийн нийт ашиг 5,567,988.4 мянган төгрөг байна. Ашигтай ажилласан ББСБ-уудын ашгийн арифметик дундаж 34,583.8 мянган төгрөг байна.

Харин нийт ББСБ-уудын 15.3 хувь буюу 29 ББСБ 1,189,684.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

ББСБ-уудын 2011 оны 2 дугаар улирлын орлого зарлагын тайлангийн нэгтгэлээс үзэхэд 2011 онд 115 ББСБ нийт 184,575.1 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хороонд төвлөрүүлсэн гэж бүртгэсэн байна.

ТАВ. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 119,933,010.9 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 117,368,853.0 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 99.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 102.2 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 69.7 хувь;

- түргэн борлогдох актив 50,805,033.6 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 31,937,841.8 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 159.1 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 2,848,933.2 мянган төгрөг, валютаарх өөрийн хөрөнгө 119,933,010.9 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 2.38 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 8,726,211.6 мянган төгрөг, хувьцаат капитал 105,336,294.0 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 8.3 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,005,166.7 мянган төгрөг, нийт актив 167,715,818.2 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.2 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 3,520,897.3 мянган төгрөгөөр байгуулбал зохиоос 1,773.4 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 3,519,123.9 мянган төгрөгөөр байгуулсан байна.¹

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж зээлийн эрсдэлийн санг бүрэн байгуулах шаарлагатай байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

- 2011 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 190 ББСБ-аас 171 ББСБ тайлангаа ирүүлсэн, 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 6.8 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 16 ББСБ буюу нийт ББСБ-ын 8.4 хувь нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдлаа.
- ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

(Давхардсан тоогоор)

/Хүснэгт 12/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2010 оны II улирал	2011 оны II улирал
1	Зээл	140	144
2	Факторингийн үйлчилгээ	6	11
3	Төлбөрийн баталгаа гаргах	6	8
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	6
6	Гадаад валютын арилжаа	110	98
7	Итгэлцлийн үйлчилгээ	9	15
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	8	12
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ² /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

Дээрх хүснэгтээс үзэхэд ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагааг дагнан болон зэрэг эрхлэж байна. Нэр бүхий 8 ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 4-5 –ийг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.

Харин гадаадын хөрөнгө оруулалттай болон томоохон банк бус санхүүгийн байгууллагууд нэмэгдэхийн хэрээр банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн

¹ Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 эзэлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх факторингийн болон итгэлцэлийн үйл ажиллагаа эрхлэх ББСБ тоо өсөх хандлагатай байна.

3. ББСБ-уудын нийт актив 2011 оны II улирлын байдлаар 167,715,818.2 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 7,691,618,190.1 мянган төгрөг/** 2.3 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 100,926,240.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн **/банкны салбарын нийт зээл 4,517,238,332.9 мянган төгрөг/** 2.4 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 4,947,202.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн **/банкны салбарын чанаргүй зээл 387,501,132.9 мянган төгрөг/** 1.3 хувь, нийт дүрмийн сан 105,336,294.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн **/банкны салбарын нийт дүрмийн сан 249,432,366.8 мянган төгрөг/** 28.2 хувьтай тус тус тэнцэж байна.
4. 2011 оны эхний хагас жилийн нэгтгэлд хамрагдсан 190 ББСБ-ын 2011 онд төвлөрүүлбэл зохих нийт 134,945.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 163 ББСБ 123,000.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 91.1 хувьтай байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР